



ХЭНТИЙ АЙМГИЙН
ЦЭНХЭРМАНДАЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2026 оны 03 сарын 31 өдөр

Дугаар А/45

Модот

Шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх
дархлаажуулалтын ажлыг зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дүгээр зүйлийн 66.1., Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.4, 9.5, 9.6, 9.7 дахь заалт, Мал эмнэлгийн ерөнхий газрын даргын 2026 оны А/59 дугаар тушаал, Хэнтий аймгийн Засаг даргын 2026 оны А/150 захирамж, Хэнтий аймгийн мал эмнэлгийн газрын даргын 2026 оны А/27 дугаар тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь

1. Шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтын арга хэмжээг сумын хэмжээний бүх үхэр, гахайг хамруулан 2026 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс 4 дүгээр сарын 20-ний хүртлэх хугацаанд мал эмнэлгийн үйлчилгээний нэжүүд шуурхай зохион байгуулсугай.

2. Дархлаажуулалтад хамрагдах малын тоо, шаардагдах вакцины хуваарийг хавсралтаар баталсугай.

3. Дархлаажуулалт хийх ажлыг малчидад урьдчилан мэдэгдэж мал сүргийг бэлэн байлгаж, бүрэн хамруулах, тарилгын хашаа, хоолойг бэлтгүүлэх ажлыг Багийн Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай.

4. Шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтад шаардлагтай вакцин татан авах, мэргэжил арга зүйн зөвлөмжөөр хангах, гүйцэтгэлд хяналт хийх, нэгдсэн тайлан дүн мэдээг Мал эмнэлгийн газарт хүргэж ажиллахыг мал эмнэлгийн улсын байцаагч (П.Ганчимэг)- т хариуцуулсугай.

5. Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахын Засаг даргын Тамгын газрын дарга (Ү.Ичинхорлоо)-д даалгасугай

ЗАСАГ ДАРГА

А.МӨНХ-ОРГИЛ



Сумын Засаг даргын 20.26
.03. дүгээр сарын 31-ны
өдрийн... дугаар
захирамжийн хавсралт

ШҮЛХИЙ ӨВЧНӨӨС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ 2026 ОНЫ ХАВРЫН
ДАРХЛААЖУУЛАЛТЫН ЦЭНХЭРМАНДАЛ СУМЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

№	ААНэгжийн нэр	Хамруулах мал, амьтан /толгой/				Шаардлагатай вакцин			
		Үхэр	Гахай	Нийт	Нийт	Тун	литр	Сер08.AFT/25 (50тун)	Хайр цаг
1	Дэрст хайрхан ХХК	11822	60	11882	11882	11900	23800	2	78
2	Цэнхэр бэлчир ХХК	3700		3700	3650	3650	7300		73
3	Үржих баян мандал ХХК	3700		3700	3750	3750	7500		74
	Нийт	19222	60	19282	19282	19300	38600	2	225

0000